

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
<b>2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....</b>	<b>4</b>
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	6
<b>2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....</b>	<b>8</b>
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	11
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	12
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	12
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3. Менежментийн захидал .....	14
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	16
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	16
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	17
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	22

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА Б.БААСАНДОРЖ  
ТАНАА

2020.03.25 № 01/933  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Баасандорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн зардал хооронд гүйлгэн зарцуулсан, тээвэр шатахууны зардал илүү гаргасан, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 05-аас 2020 оны 3 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор И.Эрдэнэцэцэг хийж гүйцэтгэв.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/1859 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Улсын бүртгэлийн ерөнхий газар нь “Монгол Улсын төр засгаас улсын бүртгэлийн чиглэлээр баримтлах бодлогыг хэрэгжүүлж, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэд, олон нийтэд чанартай, шуурхай хүргэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж тодорхойлсон.

Тус байгууллага нь “иргэн төвтэй” нийгмийг бий болгоход чиглэсэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /2016-2020/-ийн холбогдох заалт, зорилтуудыг гүйцэтгэхэд дараах үйл ажиллагааг явуулжээ. Үүнд:

- ✓ Бүртгэлийн үйл ажиллагаанд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, эрх зүйн шинэ орчинд ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх;
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 144 дүгээр тогтоолоор баталсан “Нэг иргэн-нэг бүртгэл” үндэсний хөтөлбөрийн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/209 дүгээр тушаалаар батлуулсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;
- ✓ Төсөл хөтөлбөрийн үр өгөөжийг дээшлүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- ✓ Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт оруулж, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй авах нөхцөлийг бүрдүүлэх;
- ✓ Боловсон хүчний чадавхыг дээшлүүлж, хариуцлагыг өндөржүүлэх;
- ✓ Мэдээллийн технологийн дэвшил, тоног төхөөрөмж, программ хангамжийн шинэчлэлийг хийх.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн 2018 онд хэвлэн гаргасан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дотоод аудитын хэлтэс 2019 онд харьяа орон нутаг дахь 21 газарт Үндэсний аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгч, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн улсын бүртгэлийн газар, 21 аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2019 оны эхний хагас жилийн Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох арга хэмжээг авч ажиллажээ. Улсын бүртгэлийн байгууллагын шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулалт 2019 оны эхний 6 сарын байдлаар 99.3 хувьтай байна.

21 аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс, Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын дарга нарт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, мэдээлэл байршуулах зөвлөмжийг хүргүүлжээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Улсын бүртгэлийн ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 26,333.6 сая төгрөгийн 2 хувь буюу 526.7 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 28,356.7 сая төгрөгийн 2 хувь буюу 567.1 сая төгрөгөөр тогтоосон нь төлөвлөлтийн шатны хувь хэмжээг хэвээр үлдээсэнтэй холбоотой болно.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 23 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 17 аудитад хамруулж, 6 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан 17 харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 812.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 507.3 сая төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 6.8 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 35.5 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 263.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 27 зөвлөмжийг хүргүүлээ.

### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайланг бүрэн нэгтгэсэн байна.

Төвлөрүүлсэн захирагчид төсвийг үр ашигтай захиран зарцуулах, Засгийн газрын тогтоолыг мөрдөж ажиллах, анхан шатны бүртгэл тайлагналтай холбоотой, дотоод хяналтыг сайжруулах 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

### Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 507.3 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- Хууль зүйн дотоод хэргийн яамнаас "нэг иргэн-нэг бүртгэл" хөтөлбөрийн хүрээнд ирүүлсэн сервер, тоног төхөөрөмжийг орлогод авч тайлагнаагүй./УБЕГ 428.7 сая/
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмэлт санхүүжилтээс татан төвлөрүүлсэн дүнг тохируулаагүй. /Төв аймгийн улсын бүртгэлийн хэлтэс 37.5 сая/

### Харьяа байгууллагын удирдлагад хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Архангай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс тогтоосон нормыг хэтрүүлэн 0.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" , 16.5.2. "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" , Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг, ... үнэн зөв гаргах" гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

2. Булган аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс шатахуун зардлыг тооцон олгохдоо автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг нормыг баримтлаагүй 0.6 сая төгрөгөөр илүү тооцсон, анхан шатны баримтгүй 0.4 сая төгрөгийн шатахууны зардал гаргасан, тайлант оны эцэст 4 албан хаагчийн 1.5 сая төгрөгийн цалингийн урьдчилгааны авлагын үлдэгдлийг тайлан бүртгэлд тусгаагүй зэрэг нийт 2.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн арван гурав дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", арван дөрөв дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ", 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3 "бүх өр төлбөр", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3. Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс ээлжийн амралтын мөнгө 0.4 сая төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 тоот тушаалтай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн: Зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4. Ховд аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс ажилчдын цалинг 3.7 сая төгрөгөөр зөрүүтэй тооцож олгоод авлагаар бүртгээгүй тайлагнасан. Төсвийн тухай хуулийн 6.4.1, НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.5-д заалтуудыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

5. Улсын бүртгэлийн ерөнхий газар олон жил дамнасан хувь хүнээс авах 32.8 сая төгрөгийн авлага барагдуулах арга хэмжээ аваагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай

тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Авлага барагдуулах албан шаардлага хүргүүлсэн.

6. Архангай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний орлогыг төвлөрүүлдэг арилжааны банкин дахь харилцах данснуудын орлого, зарлагын гүйлгээнд тавих хяналт сул, тайлант онд тус данснуудад төвлөрүүлсэн орлогыг банкны ажилтны буруугаас төрийн сан дахь төсвийн харилцах дансанд дутуу шилжүүлсэн байхад холбогдох арга хэмжээг аваагүй орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн 0.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "Батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл авах зардлаас 0.4 сая төгрөг, урсгал завсрын зардлаас 0.6 сая төгрөг нийт 1.0 сая төгрөгийг зардал хооронд шилжүүлэн үндсэн хөрөнгө худалдан авсан, тээвэр шатахууны зардалд бүлэг доторх бусад зардлаас 1.0 сая төгрөгийг шилжүүлэн зарцуулсан зэрэг батлагдсан төлөвлөгөөнөөс зардлыг хэтрүүлэн зарцуулсан зөрчил нь Сангийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалын 2.3.1-д " Тухайн зардлын зүйлийн ангилалд төлөвлөх ёстой байсан зардлыг өөр зардлын зүйлийн ангилалд шилжүүлэн төлөвлөх", 5.3-д " Хөрөнгийн зардлыг зөвхөн үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос санхүүжүүлнэ, урсгал зардлын хэмнэлтийг хөрөнгийн зардалд зарцуулахгүй" гэсэн заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

## 2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

### 2.9.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 58.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 48.8 сая төгрөг болж, 10.1 сая төгрөгөөр өссөн /буурсан/ байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл			/сая төгрөг/	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	39.2	39.2	0.0	80.3
Замд яваа мөнгөн хөрөнгө	19.7	9.6	-10.1	19.7
Хадгаламж				
<b>Дүн</b>	<b>58.9</b>	<b>48.8</b>	<b>-10.1</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: УБЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 2.2 сая төгрөг нь Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн ахмадын сангийн төрийн сан дахь харилцах дансанд, 2.2 сая төгрөг Нийслэлийн УБХ-ын төсвийн харилцах дансанд, 34.4 сая төгрөг УБЕГ-ын барьцаа дансанд, 0.3 сая төгрөг УБЕГ-ын арилжааны банкны дансанд, 0.065 сая төгрөг Говь сүмбэр аймгийн УБХ-ын харилцах дансанд, 0.02 сая төгрөг Увс аймгийн УБХ-ын харилцах дансанд тус тус байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 9.6 /Нийслэлийн улсын бүртгэлийн газар үйлчилгээний орлого/ сая төгрөг байна.

### Аудитын илрүүлэлт:

1. Анхан шатны баримт бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, И-баримт дутуу шивсэн, бүрдэл дутуу 96.6 сая төгрөгийн зэрэг зөрчил илэрсэн / НУБГ 59.6 сая, УБЕГ 21.1 сая, Говь сүмбэр 2.2 сая, Төв аймаг 13.7 сая/

2. Ажил олгогчийн буруугаас ажлаас халагдсан ажилтнуудад нөхөн олговрыг олгосон. /УБЕГ 53.4 сая/

3. Оны эцэст Чингис хаан цогцолборт төсвөөс ойролцоогоор нэг хүний 150.0-200.0 мянган төгрөгийн зардал гарган сургалт зохион байгуулж төсвийг үрэлгэн зарцуулсан. /УБЕГ 35.9 сая/

4. Тэтгэвэрт гарсан хүнийг үндсэн ажилтнаар үр дүнгийн гэрээ байгуулан ажиллуулж зэрэг дэв, удаан жилийн нэмэгдэл олгосон. /УБЕГ 7.6 сая/

5. Тээвэр шатахууны зардлыг хэтрүүлэн зарцуулсан, илүү худалдан авалт хийсэн, Хот дотор ажил үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см<sup>3</sup>-ээс дээш автомашин хэрэглэсэн, суудлын автомашин унах эрхгүй албан тушаалтан автомашин хэрэглэн шатахууны зардал гаргасан. /Хэнтий аймгийн УБХ 0.6 сая, Булган аймгийн УБХ 1.2 сая, Дархан аймгийн УБХ 0.06 сая, Орхон аймгийн УБХ /

### 2.9.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 760.2 сая төгрөгөөс эцсийн үлдэгдэл 416.9 сая төгрөг болж, 343.3 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.1	1.2	1.1
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага	0.6	0.7	0.1
Зээлийн хүүгийн авлага			
Бусад авлага	759.5	415.0	-344.5
<b>Дүн</b>	<b>760.2</b>	<b>416.9</b>	<b>-343.3</b>

Эх сурвалж: УБЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 61.0 сая төгрөгийн дараах авлага байна.

Үүнд:

- Өвөрхангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс: 2012 онд Сангийн яамнаас авах 0.1 сая төгрөгийн авлага;
- Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс: Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн алба нэртэй байх үед хувь хүнд акт, төлбөрөөр тавигдсан авлага 2006 онд үүссэн 8.1 сая төгрөгийн авлага;
- Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс: Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн алба байх үед хувь хүнээс авах 2008 онд үүссэн 0.6 сая төгрөгийн авлага;
- Улсын бүртгэлийн ерөнхий газар: Хувь хүнээс авах 2003 онд үүссэн 32.7 сая төгрөгийн авлага, Бодь Интернэйшнл ХХК-аас авах 2012 онд үүссэн 19.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг 2019 онд харьяа шүүхийн байгууллагад шилжүүлжээ.

### 2.9.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 4.2 сая төгрөг байна.

#### Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал		4.2	4.2
<b>Дүн</b>		<b>4.2</b>	<b>4.2</b>

Эх сурвалж: УБЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэд ахмадын сан байгуулан арилжааны банканд данс нээж 4.2 сая төгрөг шилжүүлсэн, зардал гараагүй тухайн байгууллагын дансанд үлдэгдэлтэй байна.

#### 2.9.4 Авлага

Бараа материалын эхний үлдэгдэл 6,737.2 сая, эцсийн үлдэгдэл 6,856.6 сая төгрөг болж, 119.4 сая төгрөгөөр өссөн байна.

##### Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	2,816.7	3,638.6	821.9
Бэлэн бүтээгдэхүүн	2,699.9	2,342.9	-357.0
Хангамжийн материал	1,210.9	854.9	-356.0
Мал амьтад	9.7	20.2	10.5
<b>Дүн</b>	<b>6,737.2</b>	<b>6,856.6</b>	<b>119.4</b>

Эх сурвалж: УБЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын 2019 оны жилийн эцсийн үлдэгдлийн 5,974.6 сая төгрөг буюу 87.1 хувийг УБЕГ-ын төв аппаратын бараа материалын үлдэгдэл эзэлж байна. Тухайлбал:

Тусгай зориулалттай материал цахим гадаад паспорт 897.8 сая, үндэсний энгийн гадаад паспорт 878.9 сая, иргэний үнэмлэхийн цахим бэлдэц 871.4 сая нийт 2,648.1 сая төгрөгийн материалыг 2020 оны батлагдсан төсвийн хүрээнд худалдан авалтын гэрээ байгуулж гадаад паспорт, иргэний үнэмлэхийг хүлээн авах хүртэлх хугацааны шаардлагатай үлдэгдлийг бэлтгэсэн байна.

##### Аудитын илрүүлэлт:

Бараа материалын дансанд ажилчдын хэрэглэдэг 30.7 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж бүртгэсэн./ УБЕГ/

#### 2.9.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 4,081.1 сая төгрөгөөр өссөн байна.

##### Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	6,603.0	11,160.9	4,557.9
Биет бус хөрөнгө	2,099.0	1,622.2	-476.8
<b>Дүн</b>	<b>8,702.0</b>	<b>12,783.1</b>	<b>4,081.1</b>

Эх сурвалж: УБЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант 2019 онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 180.7 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 6,439.1 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн, балансаас баланст шилжүүлсэн 1,171.2 сая, акталсан 913.3 сая төгрөгөөр хасагдсан байна.

##### Аудитын илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглаж байгаа хөрөнгөд дахин ашиглах хугацаа үнийг шинэчлэн тогтоолгоогүй, акталсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан 14 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэ тогтоогоогүй ашиглаж байгаа зэрэг зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 18 дугаар зүйлийн 18.1, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019.06.18-ны өдрийн 271 тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн. /Говь сүмбэр аймгийн УБХ 8.3 сая/

#### 2.9.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 77.4 сая төгрөг байсан нь жилийн эцсийн үлдэгдэл 51.7 сая төгрөг болж, 25.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<b>Богино хугацаат өр төлбөр дүн</b>				
Өглөг	34.1	5.1	-29.0	9.8
Бусад өглөг	31.7	35.2	3.5	68.1
Урьдчилж орсон орлого	11.6	11.4	-0.2	22.1
<b>Нийт дүн</b>	<b>77.4</b>	<b>51.7</b>	<b>-25.7</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: УБЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн үлдэгдлийн 78.1 хувь буюу 40.4 сая төгрөг нь УБЕГ-ын үлдэгдэл байна. Тухайлбал:

- Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгын санхүүжилтийн үлдэгдэл 34.4 сая;
- Монголын сагсан бөмбөгийн клуб ТББ-д өгөх 0.7 сая;
- Ажилчдад өгөх 1.7 сая;
- Байгууллагад өгөх өглөг 3.5 сая;

2.9.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 20,058.1 сая төгрөг болж, 3,877.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	12,211.5	12,211.5	0	60.9
Хуримтлагдсан үр дүн	3,349.8	7,216.9	3,867.1	36.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	619.6	619.6	0	3.05
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		10.1		0.05
<b>Дүн</b>	<b>16,180.9</b>	<b>20,058.1</b>	<b>3,877.2</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: УБЕГ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх онд тооцоо буруу хийснээс шалтгаалан 10.1 сая төгрөгийн өглөг үүссэнийг тооцоо нийлж тодруулсны үндсэн дээр бодлогын өөрчлөлт алдааны залруулга хийсэн байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сангийн сайдын 2018 оны 309 тушаалаар УБЕГ-ын 2019 онд улсын төсөвт төвлөрүүлэх орлого 19.8 сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 18.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 8.5 хувиар тасалсан байна.

Хүснэгт 2. Орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Зөрүү	Хувь
Үйлчилгээний орлого	19.8	18.1	1.7	91.4
<b>Нийт дүн</b>	<b>19.8</b>	<b>18.1</b>	<b>1.7</b>	<b>91.4</b>

Улсын төсвийн орлого 1.7 сая төгрөгөөр тасарсан нь Улсын бүртгэлийн багц хууль 2018 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж улсын бүртгэлийн үйлчилгээг цахимаар бүртгэх эрх зүйн орчин бүрдсэнээр 23 төрлийн лавлагааны үйлчилгээг иргэдэд үнэ төлбөргүй хүргэх болсноос шалтгаалсан байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 26,722.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 26,432.2 сая төгрөгийн урсгал зардал, 290.0 сая төгрөгийн хөрөнгийн зардал батлагджээ.

Улсын төсвөөс санхүүжүүлэхээр 26,722.2 сая төгрөгийг авч, гүйцэтгэлээр 26,691.2 сая төгрөгийг зарцуулж 31.0 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна.

Үүнд: Хангамж, бараа материалын зардал 0.5 илүү, цалин хөлс 7.6 сая, нийгмийн даатгалын шимтгэл 2.1 сая, эд хогшил худалдан авах зардал 2.4 сая, томилолтын зардал 2.3 сая, бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний зардал 8.4 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан байна.

Хөрөнгө оруулалтаар Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилга төсөл, арга хэмжээнд 290.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 288.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, 34.5 сая төгрөгийг барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Хандив тусламжаар Засгийн газрын нөөц сангаас 140.5 мянга, туслах аж ахуйгаас нэмэлт орлого 1.7 мянга нийт 142.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 14.7 сая, Тэтгэврийн даатгалд 4.7 сая, тээвэр шатахуунд 0.3 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 29.8 сая, дотоод албан томилолтод 0.7 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 30.0 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 6.4 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 12.8 сая нийт 99.4 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1.7 сая төгрөгийг улсын төсөвт, 41.2 сая төгрөгийг/орон нутгийн/ төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан горим сорил хэрэгжүүлж амжаагүй дараах асуудлуудыг завсрын аудитаар нарийвчлан авч үзнэ. Үүнд:

1. Хөрөнгө, бараа материалыг бодит хэрэгцээнд үндэслэн төлөвлөж, бэлтгэдэг эсэх, ашиглалт, хадгалалт үр дүнтэй байгаа эсэх;
2. Иргэний бүртгэлийн цахим лавлагааны төхөөрөмжүүдийн ашиглалт, хадгалалт, орлого бүрдүүлэлт, төвлөрүүлэлтэд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлнэ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд сар тутам хяналт тавьж, улирал тутам Хууль зүй, дотоод хэргийн яаманд мэдээг хүргүүлж ажиллажээ. Салбарын хэмжээнд нийт 23 нэгжийн 3427 мэдээлэл байршуулахаас 3326 мэдээллийг бүрэн хуулийн хугацаанд, 78 мэдээллийг хугацаа хоцроож байршуулжээ.

Үүнээс үзэхэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай байна.

## **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 5.0 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоосноос бүрэн барагдуулсан, 493.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага хүргүүлснээс 1 буюу авлага барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Нийт 16 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллажээ.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Зардлын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Тээвэр шатахууны зардлыг хэтрүүлэн зарцуулсан, Хот дотор ажил үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см<sup>3</sup>-ээс дээш автомашин хэрэглэсэн, суудлын автомашин унах эрхгүй албан тушаалтан автомашин хэрэглэн шатахууны зардал гаргасан, Ажил олгогчийн буруугаас ажлаас халагдсан ажилтнуудад нөхөн олговрыг олгосон, Анхан шатны баримт бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, тэтгэвэрт гарсан хүнийг үндсэн ажилтнаар үр дүнгийн гэрээ байгуулан ажиллуулж зэрэг дэв, удаан жилийн нэмэгдэл олгосон зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д " Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын хавсралт 2-д заасан заалттай нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Төсвийг үрэлгэн, хяналтгүй зарцуулах;

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийг үр ашигтай захиран зарцуулах, Засгийн газрын тогтоолыг мөрдөж ажиллах, дотоод хяналтыг сайжруулах;

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн хариу ирүүлсэн.**

#### **3.2 Тайлагналтай холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Зардал хооронд гүйлгэн зарцуулсан, шууд зардлаар тайлагнасан, хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2-д "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 41.2.3-д " Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах" гэсэн заалтуудтай нийцэхгүй, Сангийн сайдын 2018 оны 134 дугаар тушаалаар батлагдсан

"Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6-д" Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэсэн заалтыг зөрчсөн.

### 3.2.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгө дотоод хяналтгүй зарцуулагдах, санхүүгийн тайлан дахь зардал буруу илэрхийлэгдэж хэрэглэгчдэд зөрүүтэй мэдээлэл хүрэх;

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, хөрөнгийн ангиллыг 2020 оны 2 дугаар улиралд залруулах, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар",-ын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,556,342.1</b>	<b>7,326,593.4</b>
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	58,854.5	48,813.5
<b>АВЛАГА</b>	760,243.4	416,930.3
<b>УРЬДЧИЛГАА</b>	0.0	4,249.2
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	6,737,244.2	6,856,600.4
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,701,990.8</b>	<b>12,783,133.2</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	8,701,990.8	12,783,133.2
<b>Биет хөрөнгө</b>	6,602,970.8	11,160,925.7
<b>Биет бус хөрөнгө</b>	2,099,020.0	1,622,207.5
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>16,258,332.8</b>	<b>20,109,726.6</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>77,383.5</b>	<b>51,659.8</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>77,383.5</b>	<b>51,659.8</b>
<b>Өглөг</b>	65,814.2	40,264.2
<b>Урьдчилж орсон орлого</b>	11,569.3	11,395.6
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>16,180,949.3</b>	<b>20,058,066.8</b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>16,180,949.3</b>	<b>20,058,066.8</b>
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,211,503.2	12,211,503.2
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>3,349,862.5</b>	<b>7,226,980.0</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	619,583.7	619,583.7
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>16,258,332.8</b>	<b>20,109,726.6</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>29,863,365.8</b>	<b>32,320,325.8</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1,604,551.5	5,457,220.8
Нийтлэг татварын бус орлого	1,604,551.5	5,457,220.8
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	28,258,814.2	26,863,105.0
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>27,776,022.1</b>	<b>28,368,446.0</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	27,776,022.1	28,368,446.0
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	25,619,397.4	27,930,462.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,512,838.8	13,908,731.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,542,141.7	1,811,295.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,025,891.0	1,101,373.3
Хангамж, бараа материалын зардал	772,318.7	1,284,252.0
Эд хогшил, урсгал засварын зардал	168,456.4	121,615.5
Томилолт, зочны зардал	107,548.4	125,924.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,253,400.6	4,101,044.9
Бараа үйлчилгээний бусад зардал	4,236,801.9	5,476,225.3
<b>ТАТААС</b>	1,042.2	0.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,155,582.4	437,983.2
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>2,087,343.7</b>	<b>3,951,879.7</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,360,880.8</b>	<b>84,893.3</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-3,273,537.1</b>	<b>3,866,986.4</b>

#### 4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>54,562,626.5</b>	<b>49,806,326.8</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>25,553,986.5</b>	<b>22,922,158.4</b>
Бусад татвар, төлбөр, хураамж	25,553,986.5	22,922,158.4
Бусад нийтлэг төлбөр, хураамж	25,553,986.5	22,922,158.4
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>669,363.6</b>	<b>21,063.4</b>
Нийтлэг татварын бус орлого	669,363.6	21,063.4
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>28,339,276.3</b>	<b>26,863,105.0</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>50,759,809.4</b>	<b>49,346,811.5</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>50,759,809.4</b>	<b>49,346,811.5</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>23,811,172.9</b>	<b>25,973,559.2</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,557,978.6	13,928,352.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,498,783.5	1,796,592.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,077,409.6	1,049,231.7
Хангамж, бараа материалын зардал	649,344.6	733,439.2
Эд хогшил, урсгал засварын зардал	594,244.8	171,824.6
Томилолт, зочны зардал	113,662.4	125,924.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,632,097.4	4,303,669.1
Бараа үйлчилгээний бусад зардал	2,687,651.9	3,864,524.3
ТАТААС	1,042.2	0.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,947,594.3</b>	<b>23,373,252.3</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>3,802,817.1</b>	<b>459,515.3</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>3,808,151.7</b>	<b>469,397.0</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,808,151.7</b>	<b>469,397.0</b>
Дотоод эх үүсвэрээр	3,808,151.7	469,397.0
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-3,808,151.7</b>	<b>-469,397.0</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-9.6</b>	<b>-159.3</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>9.6</b>	<b>159.3</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-5,344.3</b>	<b>-10,041.0</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	64,198.7	58,854.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	58,854.5	48,813.5

#### 4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>14,257,274.1</b>	<b>0.0</b>	<b>14,257,274.1</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,347,615.0	0.0	4,347,615.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	18,604,889.1	0.0	18,604,889.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	587,306.4	0.0	587,306.4
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	262,291.0	0.0	262,291.0
Тайлант үеийн үр дүн	-3,273,537.1	0.0	-3,273,537.1
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>16,180,949.3</b>	<b>0.0</b>	<b>16,180,949.3</b>
<b>2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>16,180,949.3</b>	<b>0.0</b>	<b>16,180,949.3</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	10,131.0	0.0	10,131.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,191,080.4	0.0	16,191,080.4
Тайлант үеийн үр дүн	3,866,986.4	0.0	3,866,986.4
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>20,058,066.8</b>	<b>0.0</b>	<b>20,058,066.8</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>26,722,158.8</b>	<b>26,691,228.7</b>	<b>30,930.1</b>	<b>99.9</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	26,432,157.8	26,402,527.6	29,630.2	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,095,712.0	26,066,819.9	28,892.1	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,920,534.5	13,912,876.8	7,657.7	99.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,793,917.3	1,791,849.2	2,068.1	99.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,054,167.6	1,049,231.6	4,936.0	99.5
Хангамж, бараа материалын зардал	736,132.4	736,595.3	(462.9)	100.1
Эд хогшил, урсгал засварын зардал	299,186.5	296,754.4	2,432.1	99.2
Томилолт, зочны зардал	127,567.1	125,234.9	2,332.2	98.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,304,527.1	4,296,131.3	8,395.8	99.8
Бараа үйлчилгээний бусад зардал	3,859,679.5	3,858,146.4	1,533.1	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	336,445.8	335,707.7	738.1	99.8
Бусад урсгал шилжүүлэг	336,445.8	335,707.7	738.1	99.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	290,000.0	288,701.0	1,299.0	99.6
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>26,722,157.8</b>	<b>26,691,228.7</b>	<b>30,929.1</b>	<b>99.9</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>26,722,157.8</b>	<b>26,691,228.7</b>	<b>30,929.1</b>	<b>99.9</b>
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>2,479.0</b>	<b>2,479.0</b>	-	100.0
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>23.0</b>	<b>23.0</b>	-	100.0
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>1,228.0</b>	<b>1,228.0</b>	-	100.0
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>1,228.0</b>	<b>1,228.0</b>	-	100.0
Төрийн захиргааны албан хаагч /ТЗ/	1,045.0	1,045.0	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	183.0	183.0	-	100.0

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгөн хөрөнгийн 2019 оны 1-р сарын 1-ны үлдэгдэл		-
<b>ОРЛОГЫН ДҮН</b>		<b>142,246.1</b>
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,700.0
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>		<b>142,246.1</b>
<b>А.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>86,569.2</b>
<b>1. Бараа үйлчилгээний зардал</b>		<b>86,569.2</b>
<b>1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>		<b>14,674.7</b>
Үндсэн цалин		14,674.7
<b>1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл</b>		<b>4,743.6</b>
Тэтгэвэрийн даатгал		4,743.6
<b>1.3 Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>67,150.9</b>
Бичиг хэрэг		
Тээвэр, шатахуун		310.0
Шуудан холбоо		
Дотоод албан томилот		690.0
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага		
Эд хогшил худалдан авах		29,800.0
Урсгал засвар		
Байр түрээсийн хөлс		
Бусад төсөл арга хэмжээ		36,350.9
<b>Татаас ба урсгал шилжүүлэг</b>		<b>55,676.9</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг		42,902.8
Мөнгөн хөрөнгийн 2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл		-

**хавсралт**

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<i>Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020.03.25			САГ-2020/20/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Улсын бүртгэлийн ерөнхий газар		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Ажил олгогчийн буруугаас ажлаас халагдсан ажилтнуудад нөхөн олговрыг олгосон.	53.4	Зөвлөмж	УБЕГ-ын дарга, Санхүү, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Баасандорж С.Тэрбиш
2	Анхан шатны баримт бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн.	21.1	Зөвлөмж		
3	Тэтгэвэрт гарсан хүнийг үндсэн ажилтнаар үр дүнгийн гэрээ байгуулан ажиллуулж зэрэг дэв, удаан жилийн нэмэгдэл олгосон.	7.6	Зөвлөмж		
4	Оны эцэст Чингис хаан цогцолборт төсвөөс ойролцоогоор нэг хүний 150.0-200.0 мянган төгрөгийн зардал гарган сургалт зохион байгуулж төсвийг үрэлгэн зарцуулсан.	35.9	Зөвлөмж		
5	Бичиг хэргийн материал худалдан авах гэрээ жилийн дундуур хийгдсэнээс шалтгаалан тендерт шалгарснаас өөр байгууллагаас худалдан авалт хийсэн.		Зөвлөмж		
6	Олон жил дамнасан хувь хүнээс авах авлага барагдуулах арга хэмжээ аваагүй .	32.8	Албан шаардлага өгөх		
7	Бараа материалын дансанд ажилчдын хэрэглэдэг компьютер тоног төхөөрөмж бүртгэсэн.	30.7	Зөвлөмж		
	Дүн	181.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25

№ 01/169

Улаанбаатар хот

САГ- 20 20/20/СТА- ТТЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Олон жил дамнасан хувь хүнээс авах 32,792,675.00/ гучин хоёр сая долоон зуун ерэн хоёр мянга зургаан зуун далан тав / төгрөгийн авлага барагдуулах арга хэмжээ аваагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтуудыг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Олон жил дамнасан авлагыг барагдуулах арга хэмжээ авах;
- Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж, ахлах нягтлан бодогч Ч.Баасансүрэн нарт даалгав.

**ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТОР  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

**АЛБАН ШААРДЛАГЫГ:**

**ЗӨВШӨӨРСӨН:**  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА  
Б.БААСАНДОРЖ  
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ  
Ч.БААСАНСҮРЭН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie\_Kherep\Alban\_Shaardlaa\2020\03255AG3.Docx

001080560